

ЧИН УЛСЫН ҮЕИЙН АР МОНГОЛ ДАХЬ БИЧЭЭЧИЙН СУРГУУЛИЙН ТУХАЙ СУДАЛГАА

(Халхын зүүн хоёр аймгийн жишээн дээр)

ХЭРЭЙД ШИЛИ

Товч агуулга: Манж Чин улсын үед Монголын зонхилох аймаг хошуудын тамгын газар нь бичээчийн сургалт хийж, албан бичгийн аливаа ажлын тулгуур болох бичээчийг хүмүүжүүлж байсан. Энэхүү бичээчийн сургалт нь урт удаан цаг үеийг дамжин системжин боловсорч, олон засаг хошуудаар түгээмэлжиж, тухайн үеийн монголчуудын соёл боловсролын хөгжилтийг ахиулж байсан. Чингийн сүүлч үед бичээчийн сургуульд суралцаж байсан бичээч нар нь орчин үеийн монголын улс төрийн тавцанд идэвхтэй ажиллаж, тухайн үеийн нийгэм, соёлын хөгжилтөд маш чухал хувь нэмрээ үзүүлсэн. Тус өгүүлэлд, халхын Түшээт хан аймаг болон Цэцэн хан аймгаар жишээлж, тус аймаг ба харьяат хошуудад явагдаж байсан бичээчийн сургалтын тойм байдлыг танилцуулж, бас тухайн үеийн монгол бичээч нарын түүхт үйл ажиллагааг дөхөм танилцуулж, манж чингийн үеийн монгол оронд явагдаж байсан бичээчийн сургалтын түүхэн ач холбогдлын тухай өгүүлтэв.

Түлхүүр үг: Чин улсын үе, бичээч, бичээчийн сургууль

XVII зуунд Манжийн эрхшээлд байсан Монгол оронд “*хошуу чуулганы дүрэм*” гэдэг засаг захиргааны дүрэм хэрэгжүүлэгдэж байсан. Хошуу гэдэг нь засаг хошууг хэлж, энэ нь үндсэн засаг захиргааны нэгж болно. Чуулган гэдэг нь хэд буюу хэдэн арван хошуудаар бүрэлдсэн засаг захиргааны байгууламж болно. Эдгээр засаг захиргааны байгууламж нь цөм өөр өөрийн тамгын газартай байж, эдгээр тамгын газрууд нь албан бичгийн харилцаа солилцоогоор өдөр тутмын засаг захиргааны ажлаа гүйцэтгэдэг. Ийм ч учраас Манжийн ноёрхолд байсан Монгол оронд засаг захиргааны дүрэмтэйгээ зохилдсон албан бичгийн нарийн тогтолцоо бүрэлдсэн байдаг. Энэхүү албан бичгийн нарийн тогтолцоонд тулгуур хүчин болж байсан нь тамгын газрын монгол бичээч нар болно. Тухайн үед бичээч хүний улс төрийн байр суурь нь өндөр биш боловч, харин бүхий л албан бичгийн тогтолцоонд дутагдаж болшгүй байр суурьтай байсан гэж хэлэхэд арай илүүдэхгүй байх. Тэд албан бичгийг зохион боловсруулахаас эхлэн, хураан авах, явуулах, данслах, хадгалах зэрэг хамгийн үндсэн мөртлөө чухал ажлуудыг гүйцэтгэж байсан. Тухайн үеийн монгол бичээч нар нь бас манж хэл, үсэг бичигт

нэвтэрхий байж, манж монгол хэлний орчуулгад “зарчмын чанартай орчуулгын алдаа үндсэндээ гаргадаггүй” байв¹. Ийм чанга боловсролтой бичээч нар нь язгууртануудын сургууль төвлөрсөн Бээжинд биш, харин өөрсдийнхөө харьяат орон нутагтаа боловсрол хүртсэн юм. Тухайн үед бичээч хүмүүжүүлж байсан нь эл аймаг хошуудын тамгын газар болон жанжин сайдын яам зэрэг газрууд байжээ. Өөрөөр хэлбэл, эдгээр тамгын газрууд нь өдөр тутмын албан бичгийн ажлыг гүйцэтгэхээс гадна, бас бичээч хүмүүжүүлэх чухал үүргийг гүйцэтгэж байсан байна. Чин улсын үед эдгээр тамгын газарт бичээч боловсруулдаг боловсролын систем тогтворжиж, энэхүү боловсролын систем нь урт удаан түүхэн явцад монголчуудын соёл боловсролын хөгжилтөд маш чухал нөлөө тусгал үзүүлсэн юм.

Тус өгүүлэлд, Монгол улсын Үндэсний Төв Архивд хадгалагдаж байгаа манж, монгол албан бичгийн баримт материалыг ашиглаж, Чин улсын үеийн Халхын зүүн хоёр аймаг (Түшээт хан аймаг болон Сэцэн хан аймаг)-т явагдаж байсан бичээчийн сургалт болон Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын яамны газарт байгуулагдсан бичээчийн сургуулийн байдлыг тоймчлон танилцуулж, Манж Чингийн сүүлч үеийн бичээч байснаасаа Богд хаант засгийн үе болон Ардын засгийн үед улс төрийн тавцанд идэвхтэй ажиллаж, Монголын нийгэм, соёлын хөгжилтөд хувь нэмрээ үзүүлсэн бичээч гаралтай Жамъян, Магсаржав, Навааннамжил, Амар, Дэндэв нарын намтар, үйл ажиллагааг дөхөм танилцуулж, Манж Чингийн үеийн бичээчийн сургуулийн түүхэн ач холбогдлын тухай шинжлэлт хийнэ.

Нэг. Урьдах судалгаа ба сурвалжуудын тухай

Урьдах судалгааны байдал: Чин улсын үеийн монгол бичээч ба бичээчийн сургуулийн тухай тусгай судалгааны бүтээл одоо хүртэл хараахан гараагүй боловч тухайн үеийн Монгол газарт бичээчийн сургууль оршиж байсан явдлыг дурьдаж гаргасан бүтээл нь доорх мэт хэд байна.

1. Ока Хироки (ОКА Hiroki) “Чин улсын үеийн Монгол түүх судлалын сурвалжийн тухай” хэмээх өгүүлэлдээ “Чин улсын үеийн Ар Монголын эл хошууны тамгын газарт манж хэлний бичээчийг хүмүүжүүлж байсан”, “Чин улсын сүүлчийн үед манж, монгол, хятад хэлний бичээчийг хүмүүжүүлдэг сургуулийн танхимыг байгуулсан”² гэх мэтчилэн, Чин улсын үеийн Ар Монголын

¹ 中村篤志・モンゴル古文書の世界(Ⅰ)北海道立北方民族博物館友の会季刊誌 Arctic Circle (49) p.16

² 岡洋樹・清代モンゴル史研究の史料について(Ⅰ)史滴(14)p.63

хошууны бичээчийн сургууль ба Их Хүрээнд байгуулагдсан “Манж хятад бичгийн сургууль”-ийн тухай цухас дурджээ.

2. Хагихара Мамору (HAGIHARA Mamoru) “*Чин улсын үеийн Монголын шүүх ба шүүхийн бичиг*” гэх бүтээлд “Чин улсын үеийн Монголын хошуу болон аймагт хүүхдүүдийг цуглуулж, орчуулах бичээч хүмүүжүүлэх сургууль мэтийн зүйл байсан”³ гэж Чин улсын үеийн Монгол газрын хошуу ба аймагт байсан бичээчийн сургуулийн тухай дурьджээ.

3. Загчид Сэцэн ба Павол Хирийн (Sechin Jagchid and Paul Hyer) хамтын бүтээл болох “*Монголын соёл ба нийгэм*”-д “Чин улсын үеийн Монголын эл тамгын газар нь сурган хүмүүжлийн төв болж бичээч хүмүүжүүлж байсан”⁴ гэж тэмдэглэжээ.

4. Накамүра Ацүши (NAKAMURA Atsushi) “*Монгол хуучин сурвалжуудын ертөнц*” гэх өгүүлэлд Чин улсын үеийн аймгийн бичээчийн сургуулийн сурагч элсэх баримжаа ба сурагчийн гарлын тухай дөхөм өгүүлсэн зүйл харагдана⁵.

Дээр дурдсан эдгээр судалгааны бүтээлүүдэд цөм адил бусын асуудлыг адил бус харалтаас шинжлэн, Чин улсын үеийн Монгол газарт бичээчийн сургууль байсан явдлыг цухас дурьдан гаргасан боловч аль бүтээл нь ч энэхүү бичээчийн сургуулийн тухай нарийн шинжилгээ хийгээгүй.

Сурвалжуудын тухай. Тус судалгаанд голдуу доорх мэт гурван сурвалжуудыг голчлон ашиглана.

1. Ц.Шархүүгийн эмхэтгэсэн “*Манжийн дарангуйллын үеийн монголын сургууль (1776-1911)*” хэмээх албан баримт бичгийн эмхтгэл. Тус эмхтгэл нь Тэнгэр Тэтгэгчийн 41 дүгээр оноос Хэвт Ёсны 3 (1911) дугаар он хүртэлх Ар Монголын аймаг хошуудын хооронд ба аймаг болон Хүрээний сайдын яамны хооронд, бичээчийн сургуулийн явдлаар солилцсон албан бичгийн эмхтгэл болно. Тус өгүүлэлд баримт 1 гэж нэрлэе.

2. Монгол улсын Үндэсний Төв Архивд хадгалагдаж байгаа аймаг хошуудын хооронд буюу аймаг болон Хүрээний сайдын яамны хооронд бичээчийн сургуулийн явдлаар солилцсон дээрх эмхтгэлд ороогүй монгол, манж, хятад хэлний албан бичгүүд. Үүнийг баримт 2 гэж нэрлэе.

3. Г.Навааннамжилын “*Өвгөн бичээчийн өгүүлэл*” гэх дурсамж. Үүнийг баримт 3 гэж нэрлэе.

³ 萩原守・清代モンゴルの裁判と裁判文書（M）・創文社, 2006. p.151

⁴ Sechin Jagchid and Paul Hyer' Mongolia's Culture and Society (M) p.227

⁵ 中村篤志・モンゴル古文書の世界（J）北海道立北方民族博物館友の会季刊誌 Arctic Circle (49) p.17

Хоёр. Чин улсын үеийн Халхын зүүн хоёр аймгийн бичээчийн сургалтын тойм байдал

1. *Хошууны бичээчийн сургалт.* Чин улсын үеийн Ар Монголын эл тамгын газрын бичээчийн сургалт нь чухам хэзээнээс эхэлсэн бэ гэдэг асуултын тухай тодорхой баримт олдоогүй боловч, албан бичгийн баримт материалаас Түшээт хан аймгийн хошууны бичээчийн сургалт нь Тэнгэрийн Тэтгэсний 41 (1776) онд, аймгийн бичээчийн сургалт нь Тэнгэрийн Тэтгэсний 46 (1781) онд, бас Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын яамны газрын бичээчийн сургалт нь Тэнгэрийн Тэтгэсний 45 (1780) онд тус тус нэгэнт эхлээд явагдаж байсаныг мэдэж болно.

Чин улс хэдийгээр 1691 онд Ар Монголыг эрхшээлдээ оруулсан гэдэг боловч түүний ноёрхол нь тэр дороо тогтворжиж чадаагүй байсан нь мэдээж. Тухайлбал, Энх-Амгалангийн 36 (1697) онд Галдан Бошигтын довтлолыг төвшитгөж, Найралт Төвийн 6 (1728) онд Халхын дөрвөн аймгийг зохион байгуулсан. Дахибал, Найралт Төвийн 10 (1732) онд Зүүнгарын цэргийн Халхад дахин довтолсон явдлыг өнгөрүүлээд, Тэнгэрийн Тэтгэсний 21 (1756) оноос 23 (1758) он хүртэлх "Амарсанаа болон Чингүнжавын бослого"-ыг төвшитгөсөн. Бас Тэнгэрийн Тэтгэсний 23 (1758) онд Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын яамыг байгуулсан зэрэг олон үйл явдлуудыг өнгөрүүлсэн хойно, Ар Монголын улс төрийн байдал нь дөнгөж тогтворжих зүгтээ хандав. Тус орны засаг захиргааны байдал нь энэ үеэс эхэлж харьцангуй амар тогтуун байдалд орж эхэлсэн гэж үзвэл, тамгын газрын бичээчийн сургалт нь Тэнгэрийн Тэтгэсний 41 (1776) оноос эхэлсэн гэж үзэхэд буруудах зүйлгүй. Энэхүү Монгол орны тамгын газрын бичээчийн сургалт нь Манж Чингийн ноёрхлын эцсийн үе хүртэл явагдаж байсныг бид архивын баримт материалаас мэдэж болно.

Баримт 1-ийн албан бичгийг үндэслэвэл, тухайн үед Түшээт хан аймгийн чуулганы даргаас харьяат эл хошуунд албан бичиг явуулж,

"... Хошуу бүрт зохисыг үзэж, төрлийн тайж нар ба албат харцсын дотроос ухаан сайтай, номхон төлөв, бага настай хүн нар тамгынхаа газраас сонгон томилж, бичгийн хэрэгт боловсорсон түшмэл бичээч нарыг дагуулан суулгаж чандлан тушааж, хэдэн жилийн дотор эрхгүй бичиг сургагтун ..." (баримт 1, ФМ-9,Т.3, Хн-122)

хэмээн зарлиг буулгасан байна. Энэхүү зарлигийг хүлээн авсан Түшээт хан аймгийн харьяат хошууд нь тамгын газартаа тус хошууныхаа хөвгүүдийг цуглуулж, сурах бичээч болгож монгол бичиг зааж эхэлсэн явдлыг эл хошуудаас аймгийн тамгын газарт явуулсан хариу мэдүүлэлтийн бичгүүдээс мэдэж болно.

Эдгээр хариу мэдүүлэлтийн бичгүүдэд бас эл хошуудын тухайн үеийн бичээчийн сургалтад байсан хүүхдүүдийн үндсэн байдлыг харуулсан мэдээ сураг олон буй. Тухайлбал, бичээчийн сургалтад сонгогдсон хүүхэд нь цөм “төрлийн тайж буюу албат харц” гаралтай байж, “бага настай, ухаан сайтай” хөвгүүдээр голлож байсан. Эл хошуудын сонгон авсан хүний тоо ч тэгшгүй, үндсэндээ 2-4 хүн байж, 8-10 хүнийг зэргээр элсүүлсэн хошуу ч байна⁶. Зохиогчийн судалгаанаас Тэнгэрийн Тэтгэсний 45 (1780) оны үеийн Түшээт хан аймгийн бичээч хүмүүжүүлэх явдлаар хариу мэдүүлсэн 14 хошууны бүх сурагчийн тоо нь 48 хүн байж, үүний дотор тайж гаралтай нь 16 хүн, харц гаралтай нь 32 хүн байж, харцын тоо нь тайжийн тооноос илүү байжээ гэснийг мэдэж болно⁷. Энэ нь тухайн үеийн бичээчийн сургалт нь сурагчийн гэрийн гарлыг хязгаарладаггүй байсныг харуулж байна. Яг иймэрхүү гэрийн гарлын хязгаарлалгүй байсан явдал нь тухайн үеийн монгол газар нь хүүхдэд бичиг зааж бичээч болгон хүмүүжүүлэх явдалд тайж ба харц нь эрх тэгш байж, харц ардын хүүхэд ч бичээч болон хүмүүжигдэж, тамгын газарт алба хааж явах боломжийг олгосон байна.

Тухайн үед бичээчийн сургуульд сонгогдсон хөвгүүд нь цөм харьяат хошууныхаа тамгын газарт хоноглон сууж хичээл хүмүүжил хүртэж байсан. Нэг удаагийн сурлагын хугацаа нь гурван сар байж, энэ нь тамгын түшмэлийн жасаа солих хугацаатай нэгдсэн байдаг. Бичээчийн сургалт нь заах аргын талаар, баримт 3-ыг үндэслэвэл, нэг жинхэнэ бичээч нь нэг сурах бичээчийг дагуулж, тус тусад нь үсэг бичиг заан сургаж байсан мэдээ байна (баримт 3. pp.56-58). Сурах бичээч нь үсэг бичиж чадах болсон хойно, өдөр бүр олон арвин албан бичиг хуулж бичихээр бичээчийн боловсрол хийдэг байжээ.

Чин улсын үеийн Монгол орны эл тамгын газар нь “ирсэн бичгийн данс”, “явуулсан бичгийн данс” ба “өдрийн тэмдэг” гэх мэтийн албан бичгийн данс эвхмэлийг үйлдэж, албан бичгээ хадгалан тавьдаг заншилтай байжээ. Сурах бичээч нь голдуу бусад тамгын газраас ирүүлсэн албан бичгийг “ирсэн бичгийн данс”-д, бас бусад тамгын газарт явуулах албан бичгийг “явуулсан бичгийн данс”-д хуулан бичиж тавьдаг. Энэ мэтээр хошууны тамгын газарт бичээчийн боловсролыг хүртээд, “хошууны доторх албаны зарын хэргийг дөнгөж бичих зэрэгтэй болжээ” (баримт 1, ФМ-9, Т.3, Хн-73) гэх үнэлэлтийг олж чадсан сурах бичээчид үндсэндээ хоёр зүйлийн сонголт товч байдаг. Нэг нь тус хошууныхаа тамгын газарт жинхэнэ

⁶ ケレドジン, D. シーリン・清代外モンゴルにおける書記の養成 (J)・内陸アジア史研究 26・p.116

⁷ ケレドジン, D. シーリン・清代外モンゴルにおける書記の養成 (J)・内陸アジア史研究 26・p.116

бичээч болж алба хаах, нөгөө нь үргэлжлэн аймгийн тамгын газар буюу Хүрээний сайдын яаманд манж хэл сурч, дээд зэргийн орчуулагч бичээчийн боловсролыг хүртэх явдал болно.

2. *Аймгийн бичээчийн сургууль.* Чин улсын үеийн Монгол орны тамгын газар нь шаардлагаа үндэслэж монгол бичиг буюу манж бичгээр албан бичиг бичиж байсан түүхтэй. Үндсэндээ хошуу хошууны хооронд, эсвэл хошуу аймгийн хооронд монголоор албан бичиг солилцож, аймгийн хооронд буюу аймаг болон аймгаас дээших засаг захиргааны байгууламжийн хооронд манжаар албан бичиг солилцдог байсан⁸. Үүнээс үзэхэд, тухайн үед хошууны тамгын газарт адагтаа монгол бичиг мэдэх бичээч шаардагдаж, аймгийн тамгын газарт манж, монгол бичиг мэдэх бичээч шаардагдах нь дамжиггүй. Ийм ч учраас аймгийн тамгын газар нь манж бичиг зааж, монгол манж хэлийг харилцан орчуулж чадах бичээчийг хүмүүжүүлэх үүргийг гүйцэтгэж байжээ.

Одоо хүртэл олдсон Түшээт хан аймгийн аймгийн тамгын газрын бичээчийн сургалтын тухай агуулга бүхий хамаг эртний албан бичиг нь Тэнгэрийн Тэтгэсний 46 (1781) оны бичиг болно. Тус баримт нь Тэнгэрийн Тэтгэсний 46 оны 2 сард Түшээт хан аймгийн чуулганы даргаас харьяат хошууддаа манж хэл үсэг бичиг сурах хөвгүүдийг аймгийн тамгын газарт дуудсан зарлигийн бичиг (баримт 2, ФМ-9, Т.3, Хн-456) болно. Энэ зарлигийг дагаж эл хошууд нь аймгийн тамгын газарт манж бичиг суралцуулахаар хүүхэд явуулж байжээ. Аймгийн бичээчийн сургалтад ордог хүүхдүүд нь цөм харьяат хошуундаа монгол бичиг сурч эзэмшсэн 17 наснаас доошхи хөвгүүд байсныг эл хошуудын хариу мэдүүлэлтийн бичгээс мэдэж болно. Аймгийн бичээчийн сургалтад байсан хөвгүүдийг мөн ч “сурах бичээч” хэмээн нэрлэж, голдуу манж хэл үсэг бичиг сургадаг байжээ. Нэг удаагийн сурлагын хугацаа нь мөн ч гурван сар байж, сурах бичээч нар нь өөр өөрийн харьяат хошуунаасаа гурван сарын амьдралын хэрэгслээ аваад аймгийн тамгын газарт цугларан ирдэг. Амьдралын хэрэгсэлд нь “гэр, хөтөл, ачлага ба уналга, хүнс, уух ба түлээний үнэт цай” (баримт 2, ФМ-9, Т.3, Хн-456) зэргийн зүйлс багтдаг. Үүний доторх гэр гэдэг нь монгол гэрийг хэлж байна. Сурах бичээч нарын суух гэр байж, аймгийн тамгын газрын хажууд байрладаг. Хөтөл гэдэг нь хөтөч хүнийг хэлж, хөтөл нь сурах бичээчийг дагаж аймгийн тамгын газарт сууж, хоол усыг нь бэлтгэж өгдөг. Ачлага ба уналга гэдэг нь ачааны морь ба унааны морийг хэлж буй. Хүнс нь голдуу хонины мах байжээ. Бас уух ба түлээний үнэт

⁸ 萩原守・清代モンゴルの裁判と裁判文書 (M) ・創文社, 2006. p.152

цай гэдэг нь уухад зарцуулах хэвийн цай ба түлшийн төлбөрт зарцуулах хэвийн цайг тус тус зааж буй. Дээр дурьдсан эдгээр амьдралын хэрэгслийг цөм сурах бичээчийн харьяат хошуунаас ханган өгч байсан юм. Энэхүү сурагчийн амьдралын хэрэгслийн эрэлтийн тухай зарим судлаачид буруу ойлгосон байна. Жишээлбэл, Японы монголч эрдэмтэн Накамура Ациш “Аймгийн бичээчийн сургуульд орох хүүхэд нь баян айлын хөвгүүд байх хэрэгтэй. Үүний шалтгаан нь аймгийн тамгын газарт удаан хоногоор суухад хэрэгсэх хүнс ба эд хэрэгслийг хангаж чадах хэрэгтэй”⁹ хэмээн өгүүлсэн нь бодит байдалтай үл нийцнэ. Зохиогчийн судлан шинжилснээр дээр дурдсан эдгээр хэрэгсэл сурагчийн хувийн хөрөнгөөс гаргасан баримт бичиг нэг ч олдсонгүй. Харин харьяат хошууны албаны хөрөнгөнөөс гаргаж байсан баримт бичиг нилээд олдов (баримт 1, ФМ-9, Т.3, Хн-829). Үүнээс үзэхэд, тухайн үеийн аймаг болон хошууны тамгын газар нь бичээчийн сургалтаа албаны зардлаар эрхэлж байсан нь илэрхий. Яг ийм ч учраас сурагчийн гэрийн гарлыг хязгаарлах чухалгүй, тайж ба харцын хүүхдэд нэгэн адилаар бичээчийн боловсрол хүртэж, цаашлан тамгын газарт алба хааж явах завшааныг олгосон байна.

3. *Хүрээнд байгуулагдсан бичээчийн сургууль.* Чин улсын сүүлч үе хүрээд Монгол газарт хятад хэлний албан бичиг ихээр нэмэгдэсэн тул хятад хэл бичигт нэвтрэх бичээчийг хүмүүжүүлэх явдал тулган шаардагдах болсон юм. Ийм байдлын доор, тухайн үеийн Хүрээний сайдаас Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яаманд,

“... тамгын газар нэгэн албан сургуулийн гэр байгуулж, хоёр аймаг, шавь, ван, гүн, хошууны түшмэл, монгол хүний хөвгүүдээс сэцэн ухаантайг нь гаргаж тусгайлан захирсугай ...” (баримт 1, ФМ-9. Т.3, Хн-7770)

хэмээн айлтгал өргөж, Хүрээнд сургууль байгуулахыг гуйв. Энэ айлтгал нь удалгүй зөвшөөрөл олж, Бадаргуулт Төрийн 24 (1898) онд Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын яаманд “Манж хятад бичгийн сургууль” байгуулагдаж, энэ сургууль нь Халхын Түшээт хан аймаг, Сэцэн хан аймаг, шавь нарын газраас монгол үсэг бичиг буюу манж хэл үсэг бичгийн суурь мэдлэгтэй тайж, харцын хүүхдийг газар бүрээс 4-5 хүнийг сонгон авч бичээчийн сургуульдаа оруулж байв. Сургуулийн эзэгнэлтийн мөнгийг Түшээт хан аймаг, Сэцэн хан аймаг, шавь нарын газраас тус бүр жил болгон 200 лан мөнгө хураан авч байжээ. Бас сурагчдын хэрэгслийг харьяат аймгаас гаргаж байсныг албан бичгийн баримт материалаас мэдэж болно.

⁹ 中村篤志・モンゴル古文書の世界〔J〕北海道立北方民族博物館友の会季刊誌 Arctic Circle (49)p.17

Энэхүү сургууль нь Бадаргуулт Төрийн 34 (1908) онд, дахин “Сурган тэжээх сургууль” хэмээн өөрчлөгдөж, дээр дурьдсан гурван газраас сурагчийн тоог 40 хүн болгон нэмэгдүүлж, монгол, манж, хятад бичиг зааж бичээч хүмүүжүүлж байв. Тус сургууль нь заан сургалтын талаар нилээд чанга дүрэм тогтоолуудыг тогтоож, сурагч, сургагчаа чандлан шаардаж байжээ. Эдгээр тогтоолуудын дотроос хамгийн чухал бөгөөд дурьдууштай нэгэн зүйл нь сурах бичгийг тодорхой тогтоосон явдал болно. Энэ сурах бичигт “Дөрвөн зүйлийн үсэг хавсарсан толь бичиг” (баримт 1, ФМ-9. Т.3, Хн-7770), Шанзудба Дэмчигравжаагийн 1789 онд бичсэн “Цагаан толгой”¹⁰, “Оюун түлхүүр”¹¹ зэрэг бичгүүд байсан мэдээ бий.

Тухайн үеийн аймаг хошуудын тамгын газрын бичээчийг зэрэг дэсээр нь “сурах бичээч”, “туслах бичээч”, “их бичээч” гэж гурван дэст хуваадаг (баримт 3, р.56) байжээ. Бичээчийн сургалтад анх орсон хөвгүүдийг “сурах бичээч” хэмээн нэрлэж байсан юм. “Сурах бичээч” нь тогтсон хугацааны боловсролыг өнгөрүүлээд (олонхдоо гурван сарын хугацаа) “туслах бичээч”-д дэвшиж, “туслах бичээч”-ээс ахин “их бичээч”-д дэвшиж явдаг. Үүнтэй адилаар “Манж хятад бичгийн сургууль” болон “Сурган тэжээх сургууль”-д орсон хөвгүүдийг “сурагч” хэмээн нэрлэж, сургууль төгссөн сурагч нь сайдын яаманд “сурах бичээч”-ээр элсэж, “сурах бичээч”-ээс “орлогч бичээч”, “орлогч бичээч”-ээс залгаад “жинхэнэ бичээч”-д дэвшдэг дүрэмтэй байжээ. Хааяа заримдаа бичээчээс түшмэлийн зэрэгт дэвшдэг үзэгдэл ч бий (баримт 2, ФМ-9,Д-1, Хн-3665). Үүнээс үзэхэд, дээр дурдсан энэхүү бичээчийн дэвшилтын дүрэм нь тухайн үед түшмэл шалгаруулах шалгалтын дүрэм хэрэгжүүлсэнгүй монгол оронд эгэл харцын түшмэлийн зэрэг олох цөөн хэдэн арга замынх нь нэг болж байсан нь илэрхий байна.

Гурав. Манж чингийн сүүлч үеийн бичээч нарын орчин үеийн монголын нийгэм дэх үйл ажиллагаа

Манж Чингийн үеийн Ар Монголын бичээчийн сургуулийн түүхэн ач холбогдлын тухай шинжлэхэд, энэ бичээчийн сургалтын системийн дор хүмүүжигдсэн Чингийн сүүлч үеийн бичээч нарын орчин үеийн монголын нийгэм дэх үйл ажиллагааг нь мөрдөх явдал бол маш чухал ач холбогдолтой юм. Тус бүлэгт, Манж Чингийн сүүлч үеийн бичээч байсанаа Богд хаант засгийн үе болон Ардын засгийн үед улс төрийн тавцанд идэвхтэй ажиллаж, тухайн үеийн Монголын нийгэм, соёлын хөгжилд хувь нэмрээ үзүүлсэн бичээч гаралтай Жамъян,

¹⁰ Урангуа,Ж. *XX зууны эхэн үеийн Монгол улс (1911-1919)*. Улаанбаатар: 2006, р.225

¹¹ Дамдинсүрэн, Ц. *Монголын уран зохиолын тойм*. Улаанбаатар: 1957

Магсаржав, Навааннамжил, Амар, Дэндэв нарын намтар, үйл ажиллагааг дөхөм танилцуулж, Манж Чингийн үеийн бичээчийн сургуулийн түүхэн ач холбогдлын тухай шинжлэлт хийе.

1. Жамъян

Онходын Жамъян (1864-1930), Сэцэн хан аймгийн Ачит вангийн хошууны хүн. Тэр 16 настайдаа хошууныхаа тамгын газарт сурах бичээчээр сонгогдож, дараа нь туслах бичээч, их бичээч-ид дэвшин орж, хошуу, аймгийн тамгын газарт бичээчээр ажиллаж байсан түүхтэй.

Манжийн ноёрхол дуусаж, Богд хааны засаг байгуулагдсаны дараа, Жамъян 1915 онд Сангийн яамны хэрэг эрхэлсэн түшмэлд томилогдохын дагуу “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийг зохион бичих ажилд оролцжээ. 1919 онд тэрбээр хувьсгалт бүлгэмд оролцож, Монголын хоёр дахь удаагийн тусгаар тогтнолын хөдөлгөөнд идэвхтэй оролцов.

1921 оны 7 сард, Ардын засаг байгуулагдсаны дараа, Жамъян бээр Сангийн яамны дэд сайдаар томилогджээ. Мөн оны 11 сард тэрбээр “Судар бичгийн хүрээлэн”-г үүсгэн байгуулах ажилд идэвхтэй оролцож, тус хүрээлэнгийн анхны даргаар томилогджээ. Тэр бас Судар бичгийн хүрээлэнгийн харьяат номын санг үүсгэн байгуулж, тус номын сан нь хожим нь Улсын төв номын сан болсон байна. Тэрбээр Судар бичгийн хүрээлэнгийн ажлыг жолоодож байсан хугацаандаа түүх судалгааны ажлыг ч өрнүүлж, Чингис хааны мэндэлсэн газрыг сурвалжилсан зэрэг олон зохиол бүтээлээ нийтлүүлсэн байна. 1924 онд Жамъян шинээр байгуулагдсан “Ардыг гэгээрүүлэх яам”-ны сайдын тушаалыг хариуцаж, энэ хугацаандаа сургууль байгуулж, сурах бичиг найруулах ажлыг идэвхтэй өрнүүлж, тухайн үеийн суурь сурган хүмүүжлийн үйлсэд хүчин зүтгэсэн юм¹².

2. Магсаржав

Наваанлуvsанцэдэнгийн Магсаржав (1869-1935). Сэцэн хан аймгийн Далай вангийн хошууны хүн. Тэр 18 настайдаа хошууны тамгын газрын бичээч болж, 8 жил хошууны тамгийн газрын бичээчээр ажиллаж байгаад Бадаргуулт Төрийн 20 (1894) оноос аймгийн тамгын газарт их бичээч, улмаар Бадаргуулт Төрийн 31 (1905) онд Шанзудбын яаманд сонгогдож их шавийн харьяат болов.

1915 онд тэрбээр Богд хаант засгийн газрын Дотоод яамны бичээчээр томилогдож, дээр дурьдсан Жамъянтай хамт “Зарлигаар тогтоосон Монгол улсын

¹² Энхтовшин, Г. Жамъян гүн. Улаанбаатар: 1999; Пүрэвжав, Э. Онходын Жамъян. Улаанбаатар: 2003.

хууль зүйлийн бичиг”ийг зохион бичих ажилд оролцжээ. 1917 онд Дотоод яамны дэс түшмэлээр томилогдож, 1919 онд тус яамны эрхэлсэн түшмэлд дэвшин орж ажилласан. 1918 онд тэрбээр Богд хааны “Алтан навчит өргөмжлөл”ий-г зохиож, “Улсад туслагч хурц билигт дайчин гүн” хэмээх цолыг олсон бөгөөд энэ үеэс эхэлж “Магсар хурц” хэмээн олонд дуудагдах болжээ. 1921 онд тэрбээр Ардын засгийн Шүүх яамны анхны сайдаар ажиллаж, шинэ Засгийн хууль дүрмийг тогтоох, засварлах ажилд хүчээ өргөжээ. 1920-иод оны сүүлчийн үеэр түүх судлалгааны ажлыг өрнүүлж, “Монгол улсын шинэ түүх” гэх мэтийн дорвилог бүтээлүүдээ үлдээсэн байна¹³.

3. Навааннамжил

Галсан-Ишийн Навааннамжил (1882-1954). Түшээт хан аймгийн Зоригт вангийн хошууны хүн. Тэр 11 настайдаа ойр хавийнхаа бичгийн хүнээс үсэг бичиг сураад, 13 настайдаа хошууны тамгын газарт сурах бичээчээр сууж, 15 настайдаа туслах бичээч болж, Бадаргуулт Төрийн 33 (1907) онд, их бичээчид дэвшиж, хошуу, аймгийн тамгын газарт албан бичгийн ажлыг гүйцэтгэж явсан.

Ар Монголд Богд хаант засаг тогтсоны дараа Навааннамжил, Дотоод яаманд бичээч болж, сайд Цэрэнчимэдийн дор айлтгалын бичиг бичих үүргийг гүйцэтгэж байгаад 1913 онд тус яамны эх зохиох түшмэлд дэвшжээ. 1921 онд Ардын засаг байгуулагдасны дараа, тэр Засгийн газрын туслах түшмэлд томилогдож, дахин Засгийн газрын нарийн бичгийн даргад дэвшжээ. 1924 оноос хойш тэр “Ардын эрх” сонины эрхлэн найруулагч, “Уриа” хийгээд “Үнэн” сонины найруулагч зэрэг ажлуудыг хариуцаж байв. 1942 оноос хойш тэрбээр Шинжлэх ухааны хүрээлэнд түүх судлагчаар ажиллах болж, энэхүү хугацаандаа олон арвин зохиол бүтээлүүдээ нийтлүүлсэн юм¹⁴.

4. Амар

Агданбуугийн Амар (1886-1941). Түшээт хан аймгийн Эрдэнэ дайчин вангийн хошууны хүн. Бадаргуулт Төрийн 24 (1886) онд тэрбээр тухайн үеийн засаг ноён Ханддоржын зөвшөөрлийг олж, хошууны тамгын газарт сурах бичээчээр орж үсэг бичиг сурч эхлэв. Тэрбээр хошууны тамгын газарт монгол бичгээс гадна бас манж бичиг, товд бичгийг ч сурч эзэмшжээ. Гурван жил сурах бичээчээр байгаад дахин туслах бичээч, их бичээчид дэвшиж аймгийн тамгын газарт бичээчээр ажиллах болжээ.

¹³ Лонжид,З. *Магсар хурц*. Улаанбаатар:2000

¹⁴ Баримт 3-г лавлав.

1913 онд тэрбээр Богд хааны засгийн газрын Гадаад яамны эх зохиох түшмэлээр томилогдож, түүнээс хойш тус яамны дэс түшмэлд дэвшжээ. 1915 онд Гадаад яамны түшмэлийн хувиар “Хиагтын гэрээ”-г тогтоох явдалд оролцжээ. 1923 онд Ардын засгийн Гадаад яамны эрхэлсэн түшмэлээс дэвшин сайдын тушаалыг хариуцаж, 1924 оноос Сангийн яамны сайд, 1926 оноос Дотоод яамны сайд, 1928 онд Ерөнхий сайдын тушаалыг дарааллан хариуцжээ. Тэрбээр эдгээр улс төрийн чухал тушаалуудыг хариуцаж байх хугацаандаа, монгол үндэстний уламжлалт аж ахуй болох мал аж ахуйг хөгжүүлэх явдлыг ихээр хүндэтгэн, чармайн ажиллаж байснаар барахгүй, орчин үеийн Монголын аж ахуйн холбооны бүтээн байгуулалт, төмөр замын тээврийн үйлс, шуудангийн үйлсийн бүтээн байгуулалтын үндэслэгч болно. Тэр 1929 оноос эхлэн “Судар бичгийн хүрээлэн”-гийн даргаар ажиллах болсон ба энэхүү хугацаандаа тус хүрээлэнгийн судалгааны хүрээ хэвчээг өргөтгөх, залуу судлагчийг хүмүүжүүлэх, номын санг өргөтгөх, ном бичгийн хадгаламжийг баяжуулах зэрэг талаар идэвхтэй ажиллаж байсан. Үүгээр барахгүй, хувь хүний түүх судалгааны ажлыг ч идэвхтэй өрнүүлж бүтэмжтэй ажиллажээ¹⁵.

5. Дэндэв

Лхамсүрэнгийн Дэндэв (1895-1956). Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошууны хүн. Тэр 10 настайдаа ойр хавийнхаа бичгийн хүнээс үсэг бичиг сурч эзэмшээд, Бадаргуулт Төрийн 32 (1906) онд Хүрээний манж бичгийн сургуульд суралцаж байсан.

1911 онд тэр Богд хааны Засгийн газрын Дотоод яаманд бичээч болж, сайд Цэрэнчимэдийн дор айлтгалын бичиг бичих ажлыг үүрэглэж байсан. 1917 онд тус яамны эх зохиох түшмэлд дэвшжээ. 1921 онд, тэр Ардын засгийн Дотоод яамны эх зохиох түшмэл, эрхэлсэн түшмэлээр ажиллаж байгаад 1925 онд Шүүх яамны сайдын тушаалыг хариуцжээ. Энэ хэсэг хугацаанд, тэр шүүхийн дүрмийн ардчилал, шүүхийн дүрмийн өөрчлөлт, төв ба орон нутгийн шүүх хорооны бүтээн байгуулалт зэрэг олон талаар хүчлэн ажиллажээ. Тэрбээр 1927 онд, “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын шүүх цаазын бичиг”-ийг Зөвлөлтийн тусгай мэргэжилтэн нартай нэр хамт нийтлүүлэв. Дэндэв 1932 онд Шинжлэх ухааны хүрээлэнгийн даргын орлогч, 1934 онд тус хүрээлэнгийн даргаар томилогджээ. Шинжлэх ухааны хүрээлэнгийн даргийн ажлыг 8 жил хийхдээ судалгааны хүрээ

¹⁵ Болдбаатар, Ж. *Амар сайд*. Булган хот:1993; Чинбат, И. *Монгол төрийн мэргэн сайд А.Амар (1886-1941 он)*. Улаанбаатар:2005

хэвчээг өргөтгөх, судалгааны хэр хэмжээг дээшлүүлэх, Зөвлөлтийн судлаачидтай санал солилцох, залуу судлагчийг хүмүүжүүлэх зэрэг талаар чармайн ажиллажээ. Тэр Шинжлэх ухааны хүрээлэнгийн ажлыг жолоодохын дагууд өөрөө түүх судалгааны ажлыг ч идэвхтэй өрнүүлж, олон арвин судалгааны бүтээлийг нийтлүүлж, түүх судлагчийн хувьд ч алдар нэрээ мандуулсан юм¹⁶.

Дээрх танилцуулагаас бид, энэ таван хүн бүр хуучин цагийн бичээч байгаад Засгийн газрын хүнд чухал тушаалыг хариуцаж, тухайн үеийн нийгмийн улс төрийн тавцанд идэвхтэй ажиллаж, нийгэм, соёл шинжлэх ухааны хөгжилд хувь нэмрээ үзүүлсэн гэдгийг мэдэж болно. Яагаад тэд нар орчин үеийн нийгэмд ийнхүү бүтэмжтэй ажиллаж чадсан бэ? гэдэг асуултыг бид доорх хэдэн талаар шинжлэлт хийж тодруулж үзье.

1. *Нийгмийн ахуй байдлын нөлөө.* Манжийн ноёрхлоос тусгаарласан Богд хааны Засгийн газар нь төв таван яамыг байгуулж, шинэ засаг захиргааны байгууламжийг зохион байгуулсан боловч, орон нутагт үргэлжлэн хошуу чуулганы дүрмийг хэрэгжүүлсэн байна. Бас шинээр хууль цаазын дүрэм тогтоолыг тогтоосон боловч, тэр нь үндсэндээ Манжийн үеийн Монголд хэрэгжүүлж байсан хууль цаазын дүрэм тогтоолыг уул хэвээр нь залгамжилж хэрэглэсэн юм. Үүнээс үзэхэд, Богд хаант Засгийн үеийн засаг захиргааны байгууламж болон нийгмийн байгуулал нь үндсэндээ Манж Чингийн үеийн Монголын нийгмийн байгууллыг хэвээр нь залгамжилсан явдал болно. Иймээс шинээр байгуулагдсан засаг захиргааны байгууллагад явагдаж байсан албан бичгийн ажил нь Манж Чингийн үеийн тамгын газарт явагдаж байсан албан бичгийн ажилтай бараг л их зөрөө байсангүй болохоор, хуучин цагийн тамгын газрын бичээч нь шинэ засаг захиргааны байгууллагад үргэлжлэн ажиллах боломж гүйцэд байжээ. Дахин хэлбэл “шинэ” нийгэмд зохицсон засаг төрийн ажлын чадвартан ихээр шаардагдаж байсан иймэрхүү нийгмийн ахуй байдал нь хуучин цагийн бичээч нарын шинэ нийгэмд үргэлжлэн хүчээ өргөж явахад нь урьдал нөхцөл болсон юм.

2. *Манж Чингийн үеийн бичээч сургалтын дүрмийн нөлөө.* Нэгдүгээр бүлэгт өгүүлсэн мэт, Манж Чингийн үеийн бичээчийн сургалтанд олон арвин дүрэм тогтоол байсан. Эдгээр дүрэм тогтоолын дотроос гэрийн гарлыг үл хязгаарлаж байсан тогтоол нь маш чухал ач холбогдолтой юм. Дээрх танилцуулагаас бид, энэ таван хүний дотроос, зөвхөн Амар-аас бусад нь цөм харц гаралтай гэдгийг

¹⁶ Идшинноров, С. *Буруугүй буруутнууд*. Зуунмод :1993; Дэндэв, Л. *Монголын товч түүх*. Улаанбаатар:2006.

мэдэж болно. Тухайн үеийн бичээчийн сургалтын дүрэм нь гэрийн гарлыг хязгаарладаггүй байсан болохоор, тэдгээр харц гаралтай хүмүүст бичээч болон хүмүүжигдэх завшааныг адилхан олгосон байна. Гэрийн гарлын хязгаарлалыг хүлээлгүйгээр тамгын газарт сууж үсэг бичиг сурсан явдал нь тэд нарын эрдэмтэн чадвартан болж хүмүүжигдэхийн суурь нөхцөл болжээ. Бас тухайн үеийн бичээчийн ажил нь зөвхөн язгууртан тайж нарт биш, харин бүхий л хүмүүст нээгдсэн ажил байсан болохоор, нэн олон эрдэмтэн чадвартныг харцын дотроос цуглуулж чадсан байна.

3. *Бичээчийн ажлын туршлагын нөлөө.* Харц гаралтай тэд нар гэрийн гаралд хүлээслэгдсэнгүйгээр бичээчийн сургалтанд сонгогдож, бага наснаасаа бичээчийн боловсролыг системтэй хүртэж, хошуу буюу аймгийн тамгын газар, эсвэл Хүрээний сайдын яаманд бичээчээр ажилласан түүхтэй.

Тэд тамгын газрын “сурах бичээч”-ээс “туслах бичээч”, “их бичээч” болон хүмүүжигдэх явц дунд албан бичгийн аливаа ажил ба өөр бусад засаг захиргааны ажил, цаашлавал хууль зүйлийн ажлыг гүйцэтгэхээр дамжуулж, Засгийн ажлын чадвараа дээшлүүлж, ажлын туршлагыг хуримтлуулсан байна. Ахиад хэлбэл, бичээч нь засаг төрийн ажлыг гүйцэтгэдэг ноёд түшмэдтэй хамгийн ойр байдаг болохоор, ноёд түшмэдээс засаг төрийн ажлыг гүйцэтгэх арга барилыг сурч эзэмших нь тэдний өдөр тутмын ажлынх нь чухал агуулгын нэг болж байжээ. Энэ мэтээр, орчин үеийн ноёд түшмэдэд шаардагдах үндсэн чадвар болох албан бичгийн хамаа бүхий чадвар ба засаг төрийн ажлын чадварыг бүрэлдүүлсэн тэд нар орчин цагийн Монголын нийгмийн бүтээн байгуулалтад шаардагдах ховор чадвартан болж, улс төрийн тавцанд авьяас чадвараа бадруулж чадсан байна. Үүнээс гадна бичээч хүний үндсэн чадвар болох сурвалж бичгийн уншин задлах чадвар, зохион бичих чадвар, манж хэлний мэдлэг нь тэдний үнэ цэнэтэй судалгааны бүтээлийг бичихэд нь үндсэн нөхцөл болсон байна.

Товчилбол, тухайн үеийн нийгмийн ахуй байдал, Манж Чингийн үеийн Ар Монголын бичээчийн сургалтын систем жич дүрэм тогтоол, бичээчийн ажлын туршлага зэрэг нь Чин улсын сүүлч үеийн бичээч нарын орчин үеийн нийгэмд бүтээмжтэй ажиллаж, улс төр, соёл шинжлэх ухааны хөгжилд хувь нэмрээ үзүүлж чадсаны гол шалтгаан болсон байна.

Дүгнэлт

Дээр өгүүлснийг хураангуйлбал, Чин улсын үед Монгол оронд явагдаж байсан бичээчийн сургалтын систем нь тухайн үедээ олон арвин шилдэг бичээчийг хүмүүжүүлж, тухайн орны албан бичгийн засаг захиргааны ажлын саадгүй эмх цэгцтэй явагдахыг баталж чадсан байна. Нөгөө талаар, эдгээр бичээчийн сургууль нь тус газар орондоо цорын ганц албаны сургуулийн үйлдлийг бадруулж, тухайн үеийн Монгол орны үсэг бичгийн түгээмэлжилт, үндэстэний соёлын хөгжилт ба нийгмийн хөгжилтийг зохих хэмжээгээр ахиулсан байна.

Энэхүү бичээч сургалтын системээр хүмүүжигдсэн бичээч нар нь Манж Чингийн үеийн Ар Монголын албан бичгийн засаг захиргааг тулгуурлаж байснаар барахгүй, Чин улсын сүүлч үеийн бичээч нар нь орчин үеийн Монголын улс төрийн тавцанд идэвхтэй ажиллаж, тухайн үеийн монголын нийгэм, соёл шинжлэх ухааны хөгжилд чухал хувь нэмрээ үзүүлжээ. Иймийн тулд, Манж Чингийн үеийн Ар Монголын бичээчийн сургалтын систем ба энэхүү системээр хүмүүжигдсэн монгол бичээч нар нь Монголын түүхэн дээр хөнгөвчилж болшгүй чухал түүхэн ач холбогдолтой гэдгийг энд тэмдэглэе.

Abstract: This paper examines the scribes' training functions in the banner and league offices in the eastern two leagues -Tüsiyetü qan ayımay and Čečen qan ayımay-in Outer Mongolia under the Qing rule as well as the scribes' schools established at the minister-office of Yeke Kūriy-e in the late Qing period. Based mainly on historical official documents, the author sheds light on dating the time when the scribes' training was started at the league and banner offices, the methods and contents of education there and, furthermore, clarifies various details related to the scribes' training school of the late Qing period, such as the school management, contents of education and regulations. As well as The social activities of literati who studied in outer Mongolian literati schools in the late Qing Period. The conducted research attests to the significance the scribes' training system, established in Outer Mongolia under the Qing rule, had on Mongolia history. This system played an important role in accomplishing the document-based administration in Outer Mongolia. it was also a significant factor in promoting Mongolian culture through spreading Mongolian letters and improving the literacy rate in Mongolian society.

Дүгнэлт

Дээр өгүүлснийг хураангуйлбал, Чин улсын үед Монгол оронд явагдаж байсан бичээчийн сургалтын систем нь тухайн үедээ олон арвин шилдэг бичээчийг хүмүүжүүлж, тухайн орны албан бичгийн засаг захиргааны ажлын саадгүй эмх цэгцтэй явагдахыг баталж чадсан байна. Нөгөө талаар, эдгээр бичээчийн сургууль нь тус газар орондоо цорын ганц албаны сургуулийн үйлдлийг бадруулж, тухайн үеийн Монгол орны үсэг бичгийн түгээмэлжилт, үндэстэний соёлын хөгжилт ба нийгмийн хөгжилтийг зохих хэмжээгээр ахиулсан байна.

Энэхүү бичээч сургалтын системээр хүмүүжигдсэн бичээч нар нь Манж Чингийн үеийн Ар Монголын албан бичгийн засаг захиргааг тулгуурлаж байснаар барахгүй, Чин улсын сүүлч үеийн бичээч нар нь орчин үеийн Монголын улс төрийн тавцанд идэвхтэй ажиллаж, тухайн үеийн монголын нийгэм, соёл шинжлэх ухааны хөгжилд чухал хувь нэмрээ үзүүлжээ. Иймийн тулд, Манж Чингийн үеийн Ар Монголын бичээчийн сургалтын систем ба энэхүү системээр хүмүүжигдсэн монгол бичээч нар нь Монголын түүхэн дээр хөнгөвчилж болшгүй чухал түүхэн ач холбогдолтой гэдгийг энд тэмдэглэе.

Abstract: This paper examines the scribes' training functions in the banner and league offices in the eastern two leagues -Tüsiyetü qan ayimay and Čečen qan ayimay-in Outer Mongolia under the Qing rule as well as the scribes' school established at the minister-office of Ycke Kūriy-e in the late Qing period. Based mainly on historical official documents, the author sheds light on dating the time when the scribes' training was started at the league and banner offices, the methods and contents of education there and, furthermore, clarifies various details related to the scribes' training school of the late Qing period, such as the school management, contents of education and regulations, As well as The social activities of literati who studied in outer Mongolian literati schools in the late Qing Period. The conducted research attests to the significance the scribes' training system, established in Outer Mongolia under the Qing rule, had on Mongolia history. This system played an important role in accomplishing the document-based administration in Outer Mongolia. it was also a significant factor in promoting Mongolian culture through spreading Mongolian letters and improving the literacy rate in Mongolian society.

Ном зүй

Сурвалж:

1. Шархүү, Ц. (ред.) *Манжийн дарангуйллын үеийн монголын сургууль (1776-1911)*, Улаанбаатар: 1965.
2. *Монгол улсын үндэсний тов архивт хадгалагдаж байгаа дээрх эмхтгэлд орсонгүй монгол, манж, хятад хэлний албан бичгүүд.*
3. Навааннамжил, Г. *Өвгөн бичээчийн үгүүлэл*. Улаанбаатар: 1956.

Судалгааны бүтээл:

1. 岡洋樹・清代モンゴル史研究の史料について (J) 史滴(14).
2. 中村篤志・モンゴル古文書の世界 (J) 北海道立北方民族博物館友の会季刊誌 Arctic Circle (49).
3. 萩原守・清代モンゴルの裁判と裁判文書 (M) 創文社, 2006.
4. ケレドジン, D. シーリン・清代外モンゴルにおける書記の養成 (J) 内陸アジア史研究 26.
5. Болдбаатар, Ж. *Амар сайд*. Болгон хот: 1993.
6. Дамдинсүрэн, Ц. *Монголын уран зохиолын тойм*. Улаанбаатар: 1957.
7. Дэндэв, Л. *Монголын товч түүх*. Улаанбаатар: 2006.
8. Идшинноров, С. *Буруугүй буруутнууд*. Зуунмод: 1993.
9. Лонжид, З. *Магсар хурц*. Улаанбаатар: 2000.
10. Пүрэвжав, Э. *Онгодын Жамъян*. Улаанбаатар: 2003.
11. Урангуа, Ж. *XX зууны эхэн үеийн Монгол улс (1911-1919)*. Улаанбаатар: 2006.
12. Чинбат, И. *Монгол торийн мэргэн сайд А.Амар (1886-1941)*. Улаанбаатар: 2005.
13. Энхтүвшин, Г. *Жамъян гүн*. Улаанбаатар: 1999.